



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/701

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалт, аймгийн ИТХ-ын Хуралдааны 2023 оны XVII/01 тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь

1. "FAM TOUR-2023", "ITM-2023" арга хэмжээг зохион байгуулах ажлын гүйцэтгэгч "Булган аймгийн аялал жуулчлалын холбоо" ТББ-тай шууд гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. "Булган аймгийн аялал жуулчлалын холбоо" ТББ-ын ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т даалгасугай.

3. Дээрх ажилд шаардлагатай 9,300,000 (есөн сая гурван зуун мянга) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх зардлын "Ногоон хөгжлийн бодлого, аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ"-нээс санхүүжүүлэхийг сангийн нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ